

ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЫШИЛД ЗУДЫН ГАМШИГ НӨЛӨӨЛӨХ НЬ

Г.УРАНТАМИР, Д.ХИШИГДОРЖ

Нийгэм эдийн засгийн газарзүйн салбар, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, ШУА
urantamir@gmail.com

Abstract:

Mongolia stretches across between boundaries of Siberian permafrost and Central Asia's dry lands. The country has the continental climate. In recent years natural disaster occurrence has been increasing in Mongolia and it impacts negatively on socio-economic well-being, especially to livestock of herders. Dzud is one of the natural disasters with negative consequences for animal husbandry and livelihoods of pastoralists. One of reasons of the migration among pastoral herder to settlement is increase of interested towards intensive farming systems. Therefore there is urgent need to identify the proper planning of rural population. This study is conducted in the Khangai region with the highly developed agriculture industry and the Central region which is relatively more developed due to the infrastructure and mining operations. The Population and Housing Census, statistical information was used to make the analysis.

Түлхүүр үг: Хүн ам, хөдөөгийн хүн амын нутагшилт, бэлчээрийн мал аж ахуй, зуд, зудын нөлөө

ОРШИЛ

Хүн ам газар нутгаар тархан суурьшихдаа чухам ямар амьдралын хэв маягаар, ямар аж ахуй эрхлэж, хэрхэн бөөгнөрөн аж төрж байгааг харуулах орон зайн ухагдахууныг нутагшилт (Ж.Оюунгэрэл 2005) гэх бөгөөд хүний оршин суугаа хот тосгоны байдал, ажил төрөл эрхлэлт, сууцны нөхцөл, нийгмээс үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, сэтгэл ханамж зэрэг олон шалгуураар (Э.Б.Алаев 1986) ялгаатай байдаг. Судлаачид Монгол оронд хүн амын нутагшилтын дараах хэлбэрүүд (Ж.Оюунгэрэл 2005) байгааг тодорхойлжээ. Үүнд:

- Нүүдлийн мал аж ахуй эрхлэн нэг ба түүнээс дээш гэрээр хөдөө нутагт таран нутагладаг нүүдэлчдийн нутагшилтын хэлбэр
- Хөдөөгийн суурингийн нутагшилтын хэлбэр
- Хот маягийн суурингийн нутагшилтын хэлбэр
- Хотын хүн амын нутагшилтын хэлбэр

Тодорхой нутагт бэлчээрийн мал аж ахуй эрхлэн, бэлчээр сэлгэх зохистой хугацаа, орон зайн түр буудаллах үйл ажиллагааг нүүдэлч ардын нутагшилт (Х.Цэдэнсодном 2003) гэнэ. Нутаг дэвсгэрээр хүн ам тархан суурьшсан байдлыг ерөнхийд нь хүн амын байршил гэнэ (Ж.Авхинсүх, бусад, 2009). Байршлыг харуулах гол үзүүлэлт нь нягтшил (М.Баянтөр, бусад, 2012) юм. Мөн хүн амын нягтшил нь хүн амын суурьшлын нутаг дэвсгэрийн ялгааг илэрхийлнэ (Х.Цэдэнсодном, 2003). Иймд суурьшил гэдэг нь байршил гэсэн ойлголттой дүйх ухагдахуун юм.

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт бий болсон ажлын байрны хомсдол, байгалийн гамшигт үзэгдлээс (ган, зуд) шалтгаалан амьжиргааны хэдэн малаа алдаж, амьдрах аргагүй болсон малчид хөдөөнөөс хот суурин газар руу чиглэсэн “их нүүдэл”-ийг тасралтгүй хийж (Д.Базаргүр, Б.Батбуян 2007), суурьшмал амьдралын хэв маягт шилжиж байна. Өөрөөр хэлбэл байгалийн эрсдэлээс хараат аж ахуйг эрхэлж, түүгээр амьжиргаагаа залгуулж байсан нүүдэлч малчдын хот суурин газар шилжиж, амьжиргаагаа сайжруулахыг эрмэлзэж (Д.Базаргүр, бусад 2000) буй үндсэн шалтгаан нь зудын хүчин зүйл болж байна. Тухайлбал 1999-2002 оны зудад 11 сая толгой мал хорогдож, 12 000 орчим малчин өрх малгүй болсон (Ө.Эрдэнэбилэг 2016) бол 2009-2010 оны зудад 9.7 сая толгой мал хорогдож, 32756 малчин өрх малынхаа 50 хувийг алдаж, 8576 малчин өрх огт малгүй (Л.Нацагдорж 2012) болжээ. Иймд дээрхи онуудад болсон зудын нөлөөгөөр өөрчлөгдсөн хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшлыг илрүүлэх нь нэн чухал юм.

СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Тус судалгааг Үндэсний Статистикийн Хорооноос засаг захиргааны нэгжийн түвшинд гаргадаг Хөдөө аж ахуйн салбарын анхдагч тоон мэдээ материалыг ашиглан сумын түвшинд хийлээ.

Статистик тоон мэдээ материалыг зудын гамшиг болсон 2000-2002, 2009-2010 онуудаар, зудын дараах жил болох 2000-2004, 2009-2012 онуудаар, мөн 2006, 2015 онуудаар харьцуулж үзсэн.

Орон зайн тархалт, байршилт, өсөлт, бууралтын зүй тогтлыг илрүүлэхдээ суурь онуудын анхдагч тоон мэдээ материалд “Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал”, “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг ашиглан математик загварчлалын аргуудаар “Excel” программ дээр анхан шатны боловсруулалтыг хийж, зурагзүйн аргуудаар ArcGIS программ дээр сэдэвчилсэн зургууд зохиосон.

Малын тоо толгойг хонин толгойд шилжүүлэхдээ 1 тэмээ 9 хонь, 1 адуу 7 хонь, 1 үхэр 5 хонь, 1 ямаа 2 хонь (Үндэсний атлас 2009) гэсэн коэффициентийг ашиглалаа.

СУДАЛГААНД ХАМРАГДСАН НУТГИЙН ТОЙМ

Тус судалгааг дэд бүтэц, уул уурхайн үйлдвэрлэл хөгжсөн эдийн засгийн Төвийн бүс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хөгжсөн эдийн засгийн Хангайн бүсэд (зураг 1) явууллаа.



Зураг 1. Судалгаанд хамрагдсан нутаг
(Эх сурвалж: МУ-ын Үндэсний Атлас, 2009)

Монгол улсын нутаг дэвсгэрийн 54.9 хувийг эзлэх Төвийн бүс, (Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв), Хангайн бүс (Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл)-д манай орны нийт хүн амын 34.8 хувь, нийт өрхийн 36.8 хувь, малчин өрхийн 62.1 хувь, тариалсан талбайн 78.9 хувь, нийт мал сүргийн 60.2 хувь нь байршиж, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн борлуулалтын 33.4 хувь нь ногдох ба дэд бүтэц, зам харилцааны гол зангилаа, газар тариалангийн

гол цөм байрладаг улс орны хөгжлийн тулгуур бүс нутаг юм.


Тус бүс нутагт хүн ам тасралтгүй өсч байгаа бөгөөд 2006 онтой харьцуулахад 2015 онд 77.9 мянган хүнээр буюу 7.9 хувиар өсч, 1.06 сая болжээ.

ҮР ДҮН

Зудын гамшигийн нөлөөгөөр малын тоонд гарсан өөрчлөлт

Судалгааны бүс нутагт малын тоо толгой 2000 онтой харьцуулахад 2015 онд 92.6 хувь (16.2 сая толгой)-аар өсч, 33.7 сая толгой болсон боловч жил бүр тогтмол өссөнгүй, зуд тохиосон 2000-2002 (2000 онтой харьцуулахад 2002 онд 22.9 хувь) болон 2009-2010 оны хооронд (2009 онтой харьцуулахад 2010 онд 27.2 хувь) буурч (бүдүүвч 1) байжээ.


Бүдүүвч 1. Малын тоо (сая толгой), 2000-2015 он



Эх сурвалж: УЦХ, 2000-2015

2000-2002 оны зуд судалгааны ихэнх нутгийг хамарсан ба 2002 оны малын тоо толгойг 2000 онтой харьцуулахад Дундговь, Сэлэнгэ аймгаас бусад аймагт буурчээ. Тухайлбал Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Төв аймгийн ихэнх сум, Хөвсгөл, Булган аймгийн урд сумдад (зураг 2) буурч байжээ.

2009-2010 оны хооронд малын тоо толгой бүх аймагт буурсан боловч алаг цоог байдлаар цөөн хэдэн суманд өсчээ. Тухайлбал Дорноговь аймгийн баруун урд сумд болох Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Мандах сумаас бусад бүх сумд, Төв аймгийн Угтаалцайдам, Заамар, Булган аймгийн Хишиг-Өндөр, Дашинчилан, Сэлэнгэ аймгийн Орхон, Орхонтуул, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумдад малын тоо өсч, бусад сумдад (зураг 2) буурчээ.




Зураг 2. Малын тооны өөрчлөлт, 2000-2002 он, 2009-2010 он
Эх сурвалж: YCX, 2000-2002, 2009-2010

Зудын гамшигийн нөлөөгөөр хөдөөгийн хүн амын нутагшилтанд гарсан өөрчлөлт

Судалгааны нутгийн малчдын тоо 2000-2006 онд 15.5 хувиар (38 мян.хүн), 2006-2015 онд 12.1 хувиар (25.1 мян.хүн) тус тус буурчээ. Малчдын тооны өөрчлөлтийн олон жилийн динамикаас харахад зуд болсон болон зуд болсны дараах жилүүдэд (2000-2004 он, 2009-2012 он) илүү (бүдүүвч 2) буурсан байна.

Бүдүүвч 2. Малчдын тооны өөрчлөлт, мян.хүн, 2000-2015 он





Эх сурвалж: УСХ, 2000-2015

Тухайлбал 2000-2004 оны хооронд малчдын тоо 38 суманд өсч, 156 суманд буурсан бол 2009-2010 онд 32 суманд өсч, 162 суманд буурчээ. 2000 онтой харьцуулахад 2004 онд уулын ойт хээрийн бүсийн сумд болох Сэлэнгэ аймгийн ихэнх сум, Төв аймгийн зүүн хойд сумд, заримдаг цөлийн бүсийн зарим нэг сум зэрэг цөөн хэдэн суманд өсч, үлдсэн ихэнх суманд буурсан байна. 2009 онтой харьцуулахад 2012 онд томоохон хот болон аймгийн төвийн ойр орчмын сумд, аймгийн төв болон зах зээлээс хэт алслагдсан сумд, хатуу хучилттай авто зам болон төмөр зам сумын төв болон нутгаар нь дайран өнгөрдөг сумд, байгалийн бэлчээр сайн, газар тариалан эрхлэхэд тохиромжтой Сэлэнгэ, Орхон голын сав нутагт хамаарах Сэлэнгэ аймгийн ихэнх, Төв аймгийн хойд сумд, Дорноговь аймгийн зүүн сумд, Говьсүмбэр аймгийн бүх сумдад

малчдын тоо өсч, үлдсэн сумдад (зураг 3) буурчээ.

Зуд өнгөрснөөс хойш хэдэн сарын дараагаас малчид орлогын эрс дутагдалд орж, хоол хүнсний хомсдол үүсэх, өвчин хууч нь сэдрэх, хүүхдээ сургууль завсардуулах зэрэг олон сөрөг үр дагаврууд гарч эхэлдэг (Ж.Оюунгэрэл 2004) байна. Ингэж малчид хот суурин газар руу шилжсэнээр хот суурин газрын хүн ам механикаар өсч, тухайн суурин газрынхаа нийгмийн хангамж үйлчилгээг доройтуулж (Л.Нацагдорж 2012) байна. Тухайлбал 2000 онтой харьцуулахад 2004 онд аймгийн төвийн хүн ам 16.5 хувиар, сумын төвийн хүн ам 0.1 хувиар, 2009 онтой харьцуулахад 2012 онд аймгийн төвийн хүн ам 2.3 хувиар, сумын төвийн хүн ам 4.7 хувиар тус тус өсчээ. Сэлэнгэ аймгийн нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь нэмэгдэж байгаа нь нэг талаас хүн ам нь өөрийн аймгийн газар тариалан эрхлэхэд тааламжтай хөдөө нутаг руу шилжин суурьшиж байгаа, нөгөө талаас гаднаас хүн ам ихээр шилжин ирж суурьшиж байгаатай (Ж.Оюунгэрэл 2004) холбоотой юм.

Судалгааны нутгийн хэмжээнд ихэнх суманд малчдын тоо нийт дүнгээр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд ялангуяа говийн бүс нутагт илүүтэй буурсан харагдаж байна. Энэ нь бэлчээрийн доройтол, ундны усан хангамж, хуурайшилт, хөрсний үржил шим зэрэг тухайн нутгийн байгалийн нөөцийг ашиглах нөхцөл хязгаарлагдаж, өрхийн хэрэгцээг хангах боломжгүй зэрэг олон хүчин зүйлээс болж говийн бүс нутгаас нутгаа орхин, бэлчээр сайтай өөр газар луу (Б.Батбуян, бусад 2010), мал аж ахуй, газар тариаланг хоршиж эрхлэх боломж илүү таатай нөхцөлтэй бүс рүү малчид илүү шилжин нүүж (Ж.Оюунгэрэл 2004) байгаагаар тайлбарлагдана.



Зураг 3. Малчдын тооны өөрчлөлт, 2000-2004 он, 2009-2012 он
Эх сурвалж: УСХ, 2000, 2004, 2009, 2012

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хатуу хучилттай авто замын алслалтаас хамаарсан хөдөөгийн хүн амын нутагшилт

Судалгааны бүс нутагт малчдын тоо 2006-2015 оны хооронд 12.1 хувиар буюу 25.1 мян.хүнээр буурсан боловч зарим жилүүдэд өсөлт ажиглагдаж байжээ. Тухайлбал малчдын тоог 2006 онтой харьцуулахад 2007 онд 3.6 мян.хүнээр (1.7 хувь), 2012 онтой харьцуулахад 2015 онд 9.4 мян.хүнээр тус тус өсч, 181.8 мянган малчинтай болжээ. Энэ нь зудын дараах жилүүдэд суурин газарт хөдөлмөрийн насны хүн ам өсч байгаа боловч орлогын өөр эх үүсвэр, ажлын байр хайн шилжин ирсэн малчдын өсөлтийг ажлын байраар хангаж чадахгүй байгаагаас болж, буцаад мал аж ахуйгаа эрхлэж байж болох юм.

Хатуу хучилттай авто зам нь эдийн засгийн харилцаанд чухал ач холбогдолтойгоос гадна манайх шиг хөдөөгийн хүн ам нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэн, хэт сийрэг нутагшсан орны хувьд нүүдэлчдийг суурьшуулах (хотжилт) чухал (Б.Батбуян, бусад 2010) ач холбогдолтой юм.

Авто замаас алслагдах тутам малчдын өсөлтийн хувь буурч (хүснэгт 1) байна. Тухайлбал малчдын тоо тайлант онд автозам дээр орших сумдад 3.6 хувь, авто зам сумын төвийг дайраагүй боловч сумын нутгаар нь дайран өнгөрч байгаа сумдад 13.2 хувь, авто зам сумын төв болон сумын нутгийг огт дайраагүй сумдад 15.7 хувиар тус тус (хүснэгт 1) буурчээ. Эндээс малчдын тооны өөрчлөлтөнд авто зам нөлөөлж буйг харж болно.

Хүснэгт 1. Авто замын алслалтаас хамаарсан малчид болон малын тооны өөрчлөлт, 2006, 2015 он

Авто замаас хамаарсан сумын байрлал	Сумын тоо	2015 оныг 2006 онтой харьцуулсан хувиар		100 малчинд ногдох малын тоо (мян.хонин толгой)
		Малчдын тооны өөрчлөлт	Малын тооны өөрчлөлт	
		Бодит толгой	Хонин толгой	
Авто зам дээр, аймгийн төв	13	-28.8	60.6	60.2
Авто зам дээр, бусад	43	-3.6	84.2	82.1
Нутгаар дайрсан	33	-13.2	83.2	81.3
Хөрш зэргэлдээ	83	-14.7	76.7	73.4
Авто замаас хол	22	-18.8	73.3	69.8
Бүгд	194	-12.1	78.0	75.4

Эх сурвалж: *Аймгуудын статистикийн эмхэтгэл, 2006, 2015*

Мөн авто замаас алслагдах тутам малын өсөлтийн хувь болон 100 малчинд ногдох малын тоо буурч байна. Тухайлбал малын тоо толгой 78 хувиар өссөн ба үүнээс хатуу хучилттай зам сумын төвөөр дайрсан сумдад 84.2 хувиар, сумын нутгаар дайрсан сумдад 83.2 хувиар өссөн нь судалгааны бүсийн дундаж үзүүлэлтээс өндөр байгаа (хүснэгт 1) юм.

Малчдын зам дагуу хот сууринтай харилцахад дөхөм газар тосгонжин суурьшиж байгаа үйл явц улам эрчимжиж байна. Үүний баталгаа бол хот хоорондын гол авто замуудын дагуу шинээр үүсч байгаа малчдын бөөгнөрөл (Д.Базаргүр, бусад 2000) юм. Монголын нүүдэлчдийн суурьшил нь хөдөөгийн хүн амын шилжих тэмүүлэлтэй уялдан хот суурингийн татах хүрээ, үндсэн гол зам дагуу өөрсдөө “тосгонжин” төвлөрөх үйл явцаар бий болж байна. Энэ үйл явц нь хүн амын шилжих хөдөлгөөнтэй хослон хийгдэж (Д.Базаргүр, бусад 2000) байна.

Аймгийн төвийн алслалтаас хамаарсан хөдөөгийн хүн амын нутагшилт

Аливаа томоохон хот суурин газрууд нь оршин сууж буй хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангахын тулд хот орчмын бүс нутгийг үүсгэдэг. Манай оронд ч гэсэн энэ зүй тогтол ажиглагдаж (Б.Батбуян, бусад 2010) байна. Тухайлбал аймгийн төвөөс 40 хүртэл км алслагдсан сумдад тайлант онд малчдын тооны бууралт хамгийн бага байгаагаас гадна малын тоо толгойн өсөлт эсрэгээр хамгийн өндөр байна.

Эндээс эдгээр сумд аймгийн төвийн оршин суугчдыг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдээр хангах үндсэн суурь болохоос (Ч.Батдэлгэр 2003) гадна хот орчмын бүс нутгийнхан зах зээлтэй ойр учраас мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээ том хот руу нийлүүлж, малын тоо толгойгоо өсгөхийн зэрэгцээ эдийн засгийн эргэлтэнд хурдан оруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх (Б.Батбуян, бусад 2010) боломж илүү байдаг.

**Хүснэгт 2. Аймгийн төвийн алслалтаас
хамаарсан малчид болон малын тооны
өөрчлөлт, 2006, 2015 он**

Аймгийн төвөөс алслагдсан зай	Сумын тоо	2015 оныг 2006 онтой харьцуулсан хувиар			100
		Малчдын тооны өөрчлөлт	Малын тооны өөрчлөлт		ногдох малын тоо (мян.хонин толгой)
			Бодит толгой	Хонин толгой	
Аймгийн төв	13	-28.8	60.6	60.2	40.5
40 хүртэл км	17	-7.5	98.5	96	36.5
41-80 км	26	-15.9	62.1	60.9	37.8
81-120 км	38	-14.8	68.8	67.4	42.4
121-ээс дээш км	100	-11.9	86.5	81.9	40.4
Бүгд	194	-12.1	78	75.4	40.0

Эх сурвалж: *Аймгуудын статистикийн эмхэтгэл, 2006, 2015*

Аймгийн төвийн дунд болон сул үйлчлэх зайд орших сумдад малчдын тоо судалгааны бүсийн дунджаас илүү буурч байгаагаас гадна малын тоо толгойн өсөлт мөн бага байна. Харин аймгийн төвийн үйлчилж чадахгүй зайд орших сумдад малчдын тооны бууралт судалгааны бүсийн дунджаас бага байж, 100 малчинд ногдох малын тоо судалгааны бүсийн дундажтай ойролцоо (хүснэгт 2) байна. Эндээс аймгийн төвийн үйлчилж чадахгүй байгаа сумд аймгийн төвөөс хараат бусаар хөгжиж байна гэсэн таамгийг дэвшүүлж байна.

Эндээс үзэхэд аймгийн төвөөсөө 41-120 км хүртэл зайд алслагдсан сумдаас нэг талаас зах зээлээ бараадан аймгийн төвөөсөө 40 км хүртэл алслагдсан сумд руу, нөгөө талаас харьцангуй мал ихтэй малчид малын бэлчээр дагаж аймгийн төвөөсөө 121 км-ээс дээш зайд алслагдсан сумд руу шилжиж байж болох талтай.

ДҮГНЭЛТ

Судалгааны бүсийн хэмжээнд ихэнх суманд малчдын тоо буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд ялангуяа говийн бүс нутагт илүүтэй буурч байна. Энэ нь бэлчээрийн доройтол, ундны усан хангамж, хуурайшилт, хөрсний үржил шим зэрэг тухайн нутгийн байгалийн нөөцийг ашиглах нөхцөл хязгаарлагдаж, өрхийн хэрэгцээг хангах боломжгүй зэрэг олон хүчин зүйлээс болж говийн бүс нутгаас нутгаа орхин, бэлчээр сайтай, мал аж ахуй, газар тариаланг хоршиж эрхлэх боломж илүү, таатай нөхцөлтэй бүс рүү малчид илүү шилжин нүүж байна.

Зудад малаа барсан болон малынхаа ихэнх хэсгийг алдсан малчид томоохон хот, аймгийн төв, сумын төв рүү шилжиж, амьжиргааны шинэ эх үүсвэр хайн, суурин газрын хүн амыг механикаар нэмэгдүүлж байна.

Хатуу хучилттай зам тухайн сумын нутгийг дайран өнгөрснөөр хатуу хучилттай зам сумын нутгийг дайрсан сум руу бусад сумаас малчид шилжин ирж байгаа нь аймгийн төв болон нийслэл Улаанбаатарын орчимд ажиглагдаж байна. Энэ нь шууд замд татагдаж шилжиж ирсэн бус зах зээлд малаа хурдан хүргэж, эргэлтэнд оруулах, чанартай нийгмийн үйлчилгээ хүртэхийн тулд том хоттой ойр амьдрах нөхцөлөөр тосгонжин суурьшиж байгаа юм.

Хатуу хучилттай хар замаар малчид зах зээлд холбогдох давуу тал байгаа боловч малчид олноор шилжин ирснээр малаа бэлчээх талбай хомсдож, нүүдэллэх зай, нүүдлийн тоо цөөрч, бэлчээрийг сэлгэхгүй ашиглаж байгаагаас бэлчээрийн даацыг нэмэгдүүлж буй сөрөг нөлөө гарах боллоо.

Том суурингийн ойр орших сумд нь хот орчмын бүс болж, том хотыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хангах хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, хөдөөгийн хүн ам өсч эсрэгээрээ суурин газрын хүн ам буурч байна.

НОМЗҮЙ

1. Алаев Э.Б., 1986. “Социально-экономическая география: Понятийно-терминологический словарь” Москва
2. Базаргүр Д., Батбуян Б., 2007. “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм, эдийн засгийн газарзүйн тандах судалгаа” Улаанбаатар, хуу. 18
3. Базаргүр Д., Шольц Ф., Яанзен Е., Мюллер Ф.Ф., Шийрэв-Адъяа С., Батбуян Б., 2000. “Монгол улсын нийгэм эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал” Улаанбаатар, хуу. 67
4. Батбуян Б (сэдвийн удирдагч), Базаргүр Д., Энх-Амгалан С., Ганболд Б., Хишигдорж Д., Чинбаатар С., Эрдэнэтуяа С., Цогбадрах Б., 2011. “Монгол орны нийгэм эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх газарзүйн

- үндэслэл” (2008-2010) сэдэвт ажлын тайлан, Улаанбаатар, хуу. 38
5. Батдэлгэр Ч., 2003. “Томоохон хот орчмын хөдөө аж ахуйн бүс” Улаанбаатар, хуу. 13
 6. Нацагдорж Л., 2012. “Уур амьсгалын өөрчлөлт ой, ус, хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн эмзэг өртөмтгий байдал, эрсдлийн нарийвчилсан үнэлгээ” Улаанбаатар
 7. Оюунгэрэл Ж., 2004. “Нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл дэх Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд” Улаанбаатар
 8. Оюунгэрэл Ж., 2005. “Монгол улсын хүн амын байршилт, нутагшилтанд шилжих хөдөлгөөний үр дүнд гарсан өөрчлөлт” МОГЗА №4, Улаанбаатар, хуу. 168
 9. Цэдэнсодном Х., 2003. “Монголын хүн ам ба хүрээлэн буй орчин” Улаанбаатар, хуу. 68
 10. Эрдэнэбилэг Ө., 2016. “Зудыг давсан зузаан туршилага” Улаанбаатар, хуу. 3
 11. Шийрэв-Адъяа С., Чинбат Б., 2009. “М1: 5 000 000 Бүх малын тоо” Монгол Улсын Үндэсний Атлас, Сөүл, хуу. 194-195
 12. Авхинсүх Ж., Соднооваанчиг Г., Амгалан А., 2009 “Монгол улсын нийгэм эдийн засгийн газарзүй”, Улаанбаатар, хуу. 77
 13. Баянтөр М., Батцэнгэл В., Одхүү Н., Уранчимэг Г., Юмчмаа Г., 2012 “Газарзүй III сурах бичиг”, Улаанбаатар, хуу. 34